



I I I A I E U I I y a u y

0.1 ai 3,211,719...
УСХ-ны өчигдрийн мэдээгээр
Худалдах үнэ 500 төг

2018.06.25. Даваа. №125 (4975)

ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ



- “Дэлхийн сонины холбоо”-ны гишүүн
- 1999 оны шилдэг чөлөөт хэвлэл
- 2002 оны шилдэг хэвлэл
- 2013 оны Монгол Улсын шилдэг сонин
- Best of Mongolia-2016 - Оны шилдэг сонин

www.dardas.mn
facebook.com/dardas.mn
twitter.com/MMdardas
mongoliinmedeesonin@gmail.com

20 дахь жилдээ

Дугаарыг эрхэлсэн Баттөрийн ДАВААХҮҮ

ӨДРИЙН СУРВАЛЖИЛГА

БАРИМТ & ТАЙЛБАР

Бөхийн өргөө “ХАЛДЛАГА”-д өртлөө



Ц.ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ
ts.chandmanierdene@gmail.com

МҮБХ-ноос хамгаалалтын алба хөдөлгөн Бөхийн өргөөг мэдэлдээ авна хэмээн өнгөрөгч баасан гарагт Ерөнхийлөгчид мэдэгдэл хүргүүлсэн. Тэр дагуу мөн өдрийн 13:30 цагт Бөхийн өргөөнд очиход цементэн шатны дээр хэсэг хүмүүс эгнэн сууцгааж байв. Тэд тус өргөөний ажилчид аж. Өөрийгөө Бөхийн өргөөний техникч гэж танилцуулсан 50 эргэм насны эрэгтэй үүсээд буй нөхцөл байдлын талаар “Бөхийн холбооны тэргүүний асуудлаас болоод хоёр сар гаруй хугацаанд ажлаа хийж чадсангүй.”

“дэүеэеүе i ü II i z z d d”



С.БУДРАГЧАА
budragchaas@gmail.com

Монголын хамгийн даруухан, нууцлаг тэрбумтнуудын нэг бол НИТХ-ын дарга С.Амарсайхан. НИТХ-ын төлөөлөгчөөр Налайх дүүргээс хоёр удаа сонгогдсон, Монголын сайхан бүсгүйчүүдийн нэг МҮОНТВ-ийн нэвтрүүлэгч Ч.Ичинхорлоогийн нөхөр гэдгээс өөр мэдээлэлгүй шахам байсан тэрбээр НИТХ-ын даргаар сонгогдсоноосоо хойш олны анхаарлын төвд орсон юм.

“дэүеэеүе i ü III i z z d d”

**НИТХ-ын дарга С.АМАРСАЙХАН
ЗАЙСАНГИЙН 4.41 ГА ГАЗРЫГ
17.4 САЯ ТӨГРӨГӨӨР АВСАН УУ**



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

У.ХҮРЭЛСҮХ: Монголчуудын олон жилийн хүсэл биеллээ олж байна



Б.ӨНӨРТӨГТОХ
baljirunurtogtokh@gmail.com

Энэ сарын 22-нд буюу өнгөрөгч баасан гарагт Дорноговь аймгийн Алтанширээ суманд Газрын тосны боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлж, дэд бүтцийн барилгын ажлын суурийг тавьсан түүхэн үйл явдал боллоо.

“дэүеэеүе i ü III i z z d d”



“СПЕЙШЛ МАЙНЗ” хуулиа дээдэлж, хариуцлагыг НЭГДҮГЭЭРТ ТАВЬДАГ

Уул уурхайн салбарыг Монголын хөгжлийн өнөө цагийн тулгуур гэдгийг гадна, дотны эдийн засагчаас, нутгийн иргэд хүртэл хүлээн зөвшөөрөх болсон. Гагцхүү уул уурхайн салбарын бүтээн байгуулалтын үр өгөөж нь байгаль орчин, Монгол Улсын эдийн засаг, орон нутгийн иргэдийн амьжиргаанд нөлөөлж чадахуйц хариуцлагатай байж чадах уу гэдэг нь энэ салбарын том асуултын бас анхаарлын тэмдэг.

Дэлхий дахинаа уул уурхайн салбарыг осол, эндэгдэл гарах өндөр эрсдэлтэй салбар гэдгийг хүлээн зөвшөөрч эрсдлээс зайлсхийх, эрсдэлтэй нөхцөл үүссэн үед аюулыг зайлуулах технологийг хөгжүүлсээр ирсэн нь энэ салбарыг шороо, чулуутай харьцах эгэл бүдүүлэг гэхээсээ шинжлэх ухаан, технологийн нарийн горимыг ашиглах орчин цагийн “ухаалаг” салбар болгосон.

“Спейшл Майнз” нь дэлхийн хэд хэдэн орноос хөрөнгө оруулалтаа 100 хувь татан, өндөр үр чадвартай хүний нөөцийн багийг бүрдүүлж, хөдөлмөрийн үнэлэмжийг

зохиж журмын дагуу үнэлэн олгож, дээр дурдсан аюулгүй ажиллагааны технологийг нэвтрүүлэн хариуцлагатайгаар үйл ажиллагаа явуулж буй уурхайн компани юм.

Угаас эмзэг нэрхүндтэй салбараар “оролдох” болсон энэ цаг үед зарим этгээдүүдийн зүгээс зориуд манай байгууллагын үйл ажиллагааны талаар олон нийтэд буруу, ташаа ойлголтуудыг төрүүлээд байна. Иймд бид буруу ташаа ойлголтуудыг залруулж, үнэн бодит мэдээлэл өгөхийг зорилгоо.

Дэлхийн хэдэн мянган олборлогч компаниудад гардаг үйлдвэрийн санаандгүй алдаа манай уурхайд гарсан. Тэсэлгээний гэрээт компани ажлаа гүйцэтгэж байх явцад тэсэлгээний доргилтоос болж цахилгаанд масс үүсч, боловсруулах үйлдвэрийн цианитын өрөөнд цианит хэсэг хоромд савнаасаа хальсан ч үйлдвэрийн технологийн аюулгүй ажиллагааны механизмаар эргэн савандаа орсон.

“дэүеэеүе i ü VIII i z z d d”

FINE MECHANICAL WATCHMAKING, FROM JAPAN.

PRESAGE

TRIMATIC

Trimatic symbolizes three Seiko inventions that ensure the highest levels of reliability and durability in its mechanical watches.

SEIKO

SEIKO BOUTIQUE - 1	Наран Плаза, 4-р давхар, Чингисийн өргөн чөлөө-29	Утас: 99926756
SEIKO BOUTIQUE - 2	Наран Молл, 2-р давхар, Сөүлийн гудамж -42/1	Утас: 88099991
SEIKO SHOP - 1	Наран Пойнт, Хувьсгалчдын гудамж - 9	Утас: 11-326435
SEIKO SHOP - 2	Наран Центр, УИД-ын баруун талд, Энхтайвны өргөн чөлөө	Утас: 88039397

